



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баяннуур сумын цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2023/115/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Булган аймаг

2023 он

Аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ

Утас:70342580 Цахим хаяг: Erdene.B@audit.local

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn

Аудитор: З.Ганбаатар

Утас: 70342716 Цахим хаяг: Ganbaatar@audit.gov.mn

Аудитор:

Утас: 70342716 Цахим хаяг:

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
 3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
 4. Аудитын тайлан
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
 6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2022-02-24 № 144
танай _____ ны № _____ т

Баяннуур сумын ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Д.ЭНХНАРАН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн Баяннуур сумын цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баяннуур сумын цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Баяннуур сумын Цэцэрлэг нь 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 7 зорилтын хүрээнд 30 ажил төлөвлөснөөс 26 ажлыг биелүүлж биелэлт 87.7 хувийн биелэлттэйгээр тайлагнасан байна.

Тайлант онд улсын төсвөөс 284,754.0, орон нутгийн төсвөөс 49,850.1, үнэ төлбөргүй үндсэн хөрөнгө 4,469.5, бусад орлого 103.5 нийт 339,177.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж 348,871.3 мянган төгрөгийн хөрөнгө зарцуулсан байна.

Жилийн эцсээр төсөвт 44.8 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн

006020232

Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Тайлант онд Цалингийн зардлаас 10,273.6 мянган төгрөгийг ажил олгогчийн НДШ-ийн зардалд, бүлэг хооронд зөвшөөрөлгүй шилжүүлэн зориулалт бус зарцуулсан нь Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар батлагдсан төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журмын 5.5 дахь заалт, сангийн сайдын 2015 оны 01 дүгээр 20-ны өдрийн 7-р тушаалыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Баяннуур сумын СӨБ-н 2022 оны санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал илрээгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	26,396,300.00	39,392,903.71
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	5,175,303.71
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	5,175,303.71
3122	Гадаад валют	-	5,175,303.71
31221	Төрийн сангийн харилцах	-	5,175,303.71
33	АВЛАГА	-	900,000.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	900,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	26,396,300.00	33,317,600.00
354	Хангамжийн материал	26,396,300.00	33,317,600.00
35410	Бичиг хэргийн материал	3,114,000.00	273,000.00
35420	Аж ахуйн материал	20,073,900.00	21,146,400.00
35460	Хүнсний материал	3,028,400.00	11,898,200.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	373,094,657.88	351,881,017.34
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	373,094,657.88	351,881,017.34
392	Биет хөрөнгө	362,632,657.88	341,419,017.34
39201	Барилга, байгууламж, орон сууц	370,368,233.00	370,368,233.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(42,004,552.11)	(58,107,518.79)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	44,054,140.00	44,273,590.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(21,313,635.44)	(26,511,467.84)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	27,673,147.00	10,440,840.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(16,613,447.48)	(2,425,457.11)
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,252,374.00	5,752,374.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,783,601.09)	(2,371,575.92)
393	Биет бус хөрөнгө	10,462,000.00	10,462,000.00
39301	Програм хангамж	1,450,000.00	1,450,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	9,012,000.00	9,012,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	399,490,957.88	391,273,921.05
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	1,965,300.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	1,965,300.00

413	Өглөг	-	1,965,300.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	343,200.00
4136	Бусад өглөг	-	1,622,100.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	1,622,100.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	399,490,957.88	389,308,621.05
51	Засгийн газрын хувь оролцоо	399,490,957.88	389,308,621.05
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	89,253,789.00	89,253,789.00
51101	Өмч: - төрийн	89,253,789.00	89,253,789.00
512	Хуримтлагдсан үр дүн	31,328,956.25	21,146,619.42
51210	Өмнөх үеийн үр дүн	31,328,956.25	31,328,956.25
51220	Тайлант үеийн үр дүн	-	(10,182,336.83)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	278,908,212.63	278,908,212.63
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	399,490,957.88	391,273,921.05

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	317,607,065.00	339,177,050.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	500,000.00	4,572,950.00
120	Нийтлэг татварын бус орлого	500,000.00	4,572,950.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	500,000.00	4,572,950.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		4,572,950.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	317,107,065.00	334,604,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	316,907,065.00	334,604,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	278,316,800.00	284,754,000.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	38,590,265.00	49,850,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	361,644,906.59	348,871,268.65
21	УРСГАЛ ЗАРДАЛ	361,644,906.59	348,871,268.65
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	324,520,608.40	346,039,070.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	194,547,619.03	196,729,307.44
210101	Үндсэн цалин	117,554,090.06	146,567,883.66
210102	Нэмэгдэл	66,961,075.17	46,006,862.64
210104	Урамшуулал	10,032,453.80	4,154,561.14
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,553,112.78	37,645,890.48
210201	Тэтгэврийн даатгал	16,681,476.41	17,445,762.13
210202	Тэтгэмжийн даатгал	1,827,936.74	4,170,594.72
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,301,444.43	7,075,855.91
210204	Ажилгүйдлийн даатгал	365,587.43	1,347,371.67

210205	Эрүүл мэндийн даатгал	3,376,667.77	7,606,306.05
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39,010,265.00	38,978,700.00
210301	Гэрэл, цахилгаан	1,922,765.00	2,845,866.00
210302	Түлш, халаалт	37,087,500.00	35,952,834.00
210303	Цэвэр, бохир ус	-	180,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,216,426.93	78,000.00
210401	Бичиг хэрэг	469,000.00	42,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,218,796.00	36,000.00
2105	Нормативт зардал	19,263,768.89	31,497,200.00
210502	Хоол, хүнс	9,997,430.40	31,497,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	800,000.00	190,000.00
210604	Урсгал засвар	800,000.00	190,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	516,000.00	377,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	377,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,613,415.77	40,542,772.36
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,630,170.00	11,026,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,000,680.00	4,321,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	23,982,565.77	25,194,972.36
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	37,124,298.19	2,832,198.37
2132	Бусад урсгал шилжүүлэг	870,000.00	2,787,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	870,000.00	2,787,400.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	36,254,298.19	44,798.37
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	36,254,298.19	44,798.37
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(44,037,841.59)</u>	<u>(9,694,218.65)</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3,247,477.76	488,118.18
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	3,247,477.76	488,118.18
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(3,247,477.76)	(488,118.18)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(47,285,319.35)</u>	<u>(10,182,336.83)</u>

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	317,607,065.00	334,604,100.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	317,107,065.00	334,604,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	316,907,065.00	334,604,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	278,316,800.00	284,754,000.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	38,590,265.00	49,850,100.00

2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	317,607,065.00	329,428,796.29
21	УРСГАЛ ЗАРДАЛ	317,607,065.00	329,428,796.29
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	280,782,766.81	326,596,597.92
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	193,327,839.47	208,052,874.79
210101	Үндсэн цалин	108,868,988.85	138,141,946.63
210102	Нэмэгдэл	71,080,735.58	53,275,845.77
210104	Урамшуулал	13,378,115.04	16,635,082.39
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,574,262.34	27,372,323.13
210201	Тэтгэврийн даатгал	16,423,510.99	18,627,806.70
210202	Тэтгэмжийн даатгал	3,701,133.02	2,110,401.03
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,453,118.16	1,688,239.77
210204	Ажилгүйдлийн даатгал	363,454.60	725,172.62
210205	Эрүүл мэндийн даатгал	3,633,045.57	4,220,703.01
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,790,265.00	38,635,500.00
210301	Гэрэл, цахилгаан	1,922,765.00	2,502,666.00
210302	Түлш, халаалт	35,687,500.00	35,952,834.00
210303	Цэвэр, бохир ус	180,000.00	180,000.00
2105	Нормативт зардал	10,983,800.00	40,367,000.00
210502	Хоол, хүнс	10,510,700.00	40,367,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	800,000.00	799,800.00
210604	Урсгал засвар	800,000.00	799,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	450,000.00	588,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	588,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,580,200.00	10,780,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,390,900.00	7,788,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,189,300.00	2,992,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	36,824,298.19	2,832,198.37
2132	Бусад урсгал шилжүүлэг	570,000.00	2,787,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	570,000.00	2,787,400.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	36,254,298.19	44,798.37
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	36,254,298.19	44,798.37
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	=	5,175,303.71
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	5,175,303.71
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	5,175,303.71

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	89,253,789.00	278,908,212.63	77,914,525.60		446,076,527.23
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	89,253,789.00	278,908,212.63	77,914,525.60	-	446,076,527.23
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-		-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-		-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(46,585,569.35)		(46,585,569.35)
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	89,253,789.00	278,908,212.63	31,328,956.25	-	399,490,957.88
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	89,253,789.00	278,908,212.63	31,328,956.25	-	399,490,957.88
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	89,253,789.00	278,908,212.63	31,328,956.25	-	399,490,957.88
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-		-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-		-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-		-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(10,182,336.83)		(10,182,336.83)
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	89,253,789.00	278,908,212.63	21,146,619.42	-	389,308,621.05

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	334,604,100.00	329,428,796.29
21	УРСГАЛ ЗАРДАЛ	334,604,100.00	329,428,796.29
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	331,816,700.00	326,596,597.92
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	209,364,600.00	208,052,874.79
210101	Үндсэн цалин	172,677,300.00	138,141,946.63
210102	Нэмэгдэл	31,052,200.00	53,275,845.77
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	5,635,100.00	16,635,082.39
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,002,000.00	27,372,323.13
210201	Тэтгэврийн даатгал	21,093,500.00	18,627,806.70

210202	Тэтгэмжийн даатгал	2,401,500.00	2,110,401.03
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,920,900.00	1,688,239.77
210204	Ажилгүйдлийн даатгал	783,300.00	725,172.62
210205	Эрүүл мэндийн даатгал	4,802,800.00	4,220,703.01
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,680,000.00	38,635,500.00
210301	Гэрэл, цахилгаан	2,500,000.00	2,502,666.00
210302	Түлш, халаалт	36,000,000.00	35,952,834.00
210303	Цэвэр, бохир ус	180,000.00	180,000.00
210304	Байрны түрээс		
2104	Хангамж, бараа материалын зардал	-	-
210401	Бичиг хэрэг		
210402	Тээвэр, шатахуун		
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		
2105	Нормативт зардал	40,367,000.00	40,367,000.00
210502	Хоол, хүнс	40,367,000.00	40,367,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	800,000.00	800,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		
210604	Урсгал засвар	800,000.00	800,000.00
2107	Томилолт, зочны зардал		
210702	Дотоод албан томилолт		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	592,000.00	588,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		
210803	Даатгалын үйлчилгээ		
210804	Тээврийн хэрэгслийн татвар		
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	592,000.00	588,500.00
210807	Газрын төлбөр		
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,011,100.00	10,780,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,011,100.00	7,788,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,000,000.00	2,992,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,787,400.00	2,832,198.37
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,787,400.00	2,787,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,787,400.00	2,787,400.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		44,798.37
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		44,798.37
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	334,604,100.00	334,604,100.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	284,754,000.00	284,754,000.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	284,754,000.00	284,754,000.00
13200	Орон нутгийн төсвөөс санхүүжих	49,850,100.00	49,850,100.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС		
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	9.00	9.00

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00
210402	Тээвэр, шатахуун	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тухайн жил 7 зорилтын хүрээнд 30 ажил төлөвлөснөөс 26 ажлыг биелүүлж биелэлт 87.7 хувиар дүгнүүлжээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Монгол Улсын Үндсэн хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль тогтоомж болон бусад холбогдох хууль журмыг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй, НБББББ-ийг 2020 оны 09 дүгээр сарын 29-ны өдрийн А/424 дугаар тушаалаар шинэчлэн баталсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Булган аймгийн Баяннуур сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад *нийцсэн байна*.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баяннуур сумын СӨБ нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 8.2 сая төгрөгөөр буюу 9.7 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган

төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	26,936.3	33,317.6	6,381.3
Үндсэн хөрөнгө	373,094.6	351,881.0	-21,213.6
Нийт хөрөнгө	399,490.9	391,273.9	8,217.0
Өр төлбөр		0	0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	89,253.8	89,253.8	0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	399,490.9	391,273.9	8217.0

Дээрх хүснэгтээс харахад бараа материал өмнөх оны үзүүлэлтээс 6.3 мянган төгрөгөөр нэмэгдэж, үндсэн хөрөнгө 21,213.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 17,982.30 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталсан байна.

Тайлангийн хугацаанд төсвийн хөрөнгөөр 51,540.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авч 44,618.9 мянган төгрөгийн бараа материал зарцуулсан байна. Тайлант онд шилжсэн, шилжүүлэн авсан өөрчлөлтгүй тайлагнасан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Баяннуур сумын СӨБ нь 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 376,785.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 376,785.0 мянган төгрөгөөр тооцож, төлөвлөн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Тус байгууллагаас хүргүүлсэн төсвийн төслийг 92,031.0 мянган төгрөгөөр бууруулан 284,754.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд төсвийн төслөөр хүргүүлсэн дүнг 92,031.0 мянган төгрөгөөр буурсан нь 5 жилийн тэтгэмж байгууллагаар дамжихгүй ТТЗ-аас шилжүүлсэнтэй холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд хөтөлбөрийн арга хэмжээг хэрэгжүүлэхээр 284,754.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, орон нутгийн төсвөөс 49,850.1 урсгал үйл ажиллагаанд 329,428.8 мянган төгрөгийг зарцуулж, 5,175.3 мянган төгрөгийг дансны үлдэгдэлтэй байна.

Тус онд 329,428.8 мянган төгрөгийн бараа ажил үйлчилгээний зардалд зарцуулснаас цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 208,052.9 мянган төгрөг нийт зардлын 63.1 хувь, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 27,372.3 мянган төгрөг нийт зардлын 8.3 хувь, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 38,635.5 мянган төгрөг нийт зардлын 11.7 хувь, норматив зардал 40,367.0 мянган төгрөг нийт зардлын 12.3 хувь, урсгал засварын зардалд 799.8 мянган төгрөг нийт зардлын 0.2 хувь, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 588.5 мянган төгрөг нийт зардлын 0.2 хувь, бараа үйлчилгээний бусад зардалд 10,780.6 мянган төгрөг нийт зардлыг 3.2 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	81605 Эрүүл мэндийг дэмжих	800.0	800.0	0	100
2	81807 Хүүхдийн хоол	40,367.0	40,367.0	0	100
3	81816 Хүүхдэд ээлтэй орчин	1,214.2	1,214.0	2.2	99.8
4	81823 Боловсролын байгууллагын баг ажилчдын мэргэжил дээшлүүлэх	800,0	580,0	220.0	72.5
5	81834 Боловсролын стандарт сургалт	212,404.2	209,893.3	2,510.9	98.8
6	81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа	29168,6	26,726.5	2,442.1	91.6

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. 2022 онд цэцэрлэг нь нэмэлт санхүүжилт аваагүй болно

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баяннуур сумын СӨБ 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Баяннуур сумын СӨБ Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор З.Ганбаатар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүжилтийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүжилтийн дүнгийн 334,604.1 мянган төгрөгөөс 75 хувиар буюу 5,019.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын гүйцэтгэлийн шатанд дахин хянаж шинэчлэн тогтоох *шаардлагагүй* гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь баталсан төсвөөс 5,175.3 мянган төгрөгийн бодит хэмнэлт хийж ажилласан байна.

Аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тухайн жилд шилэн дансанд нийт 149 мэдээ мэдээлэхээс хугацаа хоцроосон 4 мэдээлэл дутуу оруулж мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь:

Зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Цалингийн зардлаас 10,273,567.35 төгрөгийг ажил олгогчийн НДШ-ийн зардалд, бүлэг хооронд зөвшөөрөлгүй шилжүүлэн зориулалт бус зарцуулсан нь Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар батлагдсан төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журмын 5.5 дахь заалт, сангийн сайдын 2015 оны 01 дүгээр 20-ны өдрийн 7-р тушаалыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай /бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Баяннуур сумын цэцэрлэг нь 2022 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 06 тоот албан бичгээр албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн биелэлтийг хүргүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	0		0		0
Албан шаардлага	1	0	1	0	0
Зөвлөмж	1	0	1	0	100
Нийт дүн	2		2		100

Хэрэгжээгүй төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж байхгүй болно.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Үндсэн хөрөнгө болон бараа материалыг хагас болон жилийн эцсийн тооллогоор тооцоо бодсон акт үйлдэж ажиллах шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 20,066.80 сая төгрөгийн зөрчил илэрснээс 159.0 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 19,907.8 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 2 зөвлөмж хүргүүлэн ажиллаа.

5.1 Төлбөрийн акт

1.Тайлант онд 80,500.0 төгрөгийн шатахуун дутагдуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-т "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4-т "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллага үрэгдүүлж, дутаасан хөрөнгийн тооцоог түүний өртөг болон зах зээлийн үнийн аль өндрөөр хийнэ" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлангийн аудитын тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2. тайлант онд хоолны зардлыг тогтоосон нормативаас 78,550.0 төгрөгийг илүү зарцуулсанд төлбөрийн акт тогтоолоо.

5.2 Албан шаардлага

1. Цалингийн зардлаас 10,273,567.35 төгрөгийг ажил олгогчийн НДШ-ийн зардалд, бүлэг хооронд зөвшөөрөлгүй шилжүүлэн зориулалт бус зарцуулсан нь Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар батлагдсан төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журмын

5.5 дахь заалт, сангийн сайдын 2015 оны 01 дүгээр 20-ны өдрийн 7-р тушаалыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна

2. Тайлант онд Ихэр-Тулга"ххк"-аас нийт 14,885,700.0 төгрөгийн хүнсний материал худалдан авснаас 5,251,500.0 төгрөгийн е-баримтыг шивж, анхан шатны баримтын иж бүрдэл дутуу е баримтгүй 9,634,200.0 төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн тооллоготой холбоотой асуудал

Илрүүлэлт: Ерөнхий нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материалын хагас жил болон жилийн эцсийн тооллогод тооцоо бодсон акт үйлээгүй нь Сангийн сайдын 347 дугаар тушаалаар баталсан бүртгэлийг хэвшээгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Байгууллагын хөрөнгийн тооллогыг хийхдээ чанартай хийж дотоод хяналтыг сайжруулж ажиллах.

2. Шилэн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант онд нийт 149 мэдээллээс 4 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

Өгсөн зөвлөмж:

Хуульд заасан хугацаанд тогтмол үнэн, зөв мэдээлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Баяннуур СӨБ	6	20,066.8	2	159.0	2	19,907.8	2	0				
Дүн	6	20,066.8	2	159.0	2	19,907.8	2	0				